



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД:НТАГ-2025/610/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Аудитор: Р.Баярмаа
Утас: 325093 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn

Улаанбаатар хот
2025 он

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ИХАШШ	Иргэний хэргийн анхан шатны шүүх
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амгын гудамж, Соёлын тэн өргөө, 7 корпус, 6 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: usa@aud.gov.mn, Вебсайт: www.aud.gov.mn

Хол: 02.25 № 01/189
Хол: _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ГАНХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган шинээр барих үйл ажиллагааны хүрээнд "Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтэс"-ийг 10 орон тоотойгоор шинээр байгуулсан байна. Тус хэлтсийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлуулахаар Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбарт 2 удаа албан бичгээр хандсан боловч одоог хүртэл шийдвэрлээгүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлэл байршуулаагүй, цахим дэлгүүрт бүртгэлгүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтод түвшний хэмжээнд 44 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 90.4 хувьтай гэж тайлагнасан байна.

02003680

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,959,062,771.31	7,935,874,921.00
33	АВЛАГА	20,100,000.00	20,100,000.00
335	Бусад авлага	20,100,000.00	20,100,000.00
3351	Байгууллагаас авах авлага	20,100,000.00	20,100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,918,671.31	33,730,821.00
351	Түүхий эд материал	12,000,000.00	12,000,000.00
35110	Тусгай зориулалттай материал	12,000,000.00	12,000,000.00
354	Хангамжийн материал	44,918,671.31	21,730,821.00
35410	Бичиг хэргийн материал	5,840,300.00	2,358,248.00
35420	Аж ахуйн материал	3,456,248.00	892,500.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,230,000.00
35470	Бусад хангамжийн материал	35,622,123.31	17,250,073.00
36	НӨӨЦИЙН БАРАА	7,882,044,100.00	7,882,044,100.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	7,882,044,100.00	7,882,044,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,699,974,539.75	4,914,125,020.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,699,974,539.75	4,914,125,020.55
392	Биет хөрөнгө	44,764,284.39	232,925,395.21
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,696,500.00	241,191,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,230,616.43)	(29,274,248.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,500,018.00	51,500,018.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,965,693.11)	(51,039,393.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	562,423,900.00	562,423,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(534,659,824.07)	(541,876,680.83)
393	Биет бус хөрөнгө	4,655,210,255.36	4,681,199,625.34
39301	Програм хангамж	1,450,000.00	1,450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(628,333.32)	(1,014,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,654,388,588.68	6,146,292,082.68
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,465,527,457.42)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,659,037,311.06	12,849,999,941.55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,659,037,311.06	12,849,999,941.55
51	Засгийн газрын хувь оролцоо	12,659,037,311.06	12,849,999,941.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,169,845,440.00	2,169,845,440.00
51101	Өмч: - төрийн	2,169,845,440.00	2,169,845,440.00
512	Хуримтлагдсан үр дүн	10,489,191,871.06	10,680,154,501.55
51210	Өмнөх үеийн үр дүн	10,898,979,519.78	10,489,191,871.06
51220	Тайлант үеийн үр дүн	(409,787,648.72)	190,962,630.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,659,037,311.06	12,849,999,941.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,160,073,208.29	1,821,927,136.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	291,335,518.00	247,287,536.58
120	Нийтлэг татварын бус орлого	291,335,518.00	247,287,536.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	291,335,518.00	247,287,536.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	176,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	291,160,518.00	247,111,536.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	868,737,690.29	1,574,639,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	778,460,670.29	1,574,639,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	778,460,670.29	1,574,639,600.00
1330	Төсвийн захирагчдаас	90,277,020.00	-
133003	Хөрөнгийн	90,277,020.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	887,670,319.01	1,630,964,506.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	887,670,319.01	1,630,964,506.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,070,319.01	1,025,536,391.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,093,980.67	726,207,637.84
210101	Үндсэн цалин	344,501,833.68	499,187,654.34
210102	Нэмэгдэл	81,936,483.33	86,684,507.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,484,756.24	100,549,534.29
210104	Урамшуулал	62,170,907.42	39,785,942.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,826,927.38	95,464,678.02
210201	Тэтгэврийн даатгал	50,949,585.23	47,630,307.06
210202	Тэтгэмжийн даатгал	5,866,797.47	9,777,982.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,526,526.42	8,356,541.27
210204	Ажилгүйдлийн даатгал	1,044,001.68	4,750,544.43
210205	Эрүүл мэндийн даатгал	10,440,016.58	24,949,303.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,208,000.00	45,752,000.00
210302	Түлш, халаалт	-	280,000.00
210304	Байрны түрээс	68,208,000.00	45,472,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,433,999.84	59,777,059.40
210401	Бичиг хэрэг	7,386,515.00	10,586,422.00
210402	Тээвэр, шатахуун	7,371,300.00	14,159,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,801,962.84	4,578,009.09
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	264,000.00	1,050,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,610,222.00	7,882,698.00
210408	Бараа материал акталсны зардал	-	21,520,500.31
2105	Нормативт зардал	768,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	768,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,340,500.00	1,990,200.00
210604	Урсгал засвар	1,340,500.00	1,990,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	141,482,778.00	53,972,460.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	137,247,412.00	45,300,000.00

**НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	149,000.00
210807	Газрын төлбөр	4,235,366.00	8,464,570.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	58,890.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,916,133.12	42,372,355.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,861,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	480,000.00	1,040,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,436,133.12	34,470,855.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,600,000.00	605,428,115.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,600,000.00	7,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,600,000.00	7,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	598,028,115.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	598,028,115.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>272,402,889.28</u>	<u>190,962,630.49</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	682,190,538.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	682,190,538.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(682,190,538.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(409,787,648.72)</u>	<u>190,962,630.49</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>868,737,690.29</u>	<u>1,574,815,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	176,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	176,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	176,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	176,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	868,737,690.29	1,574,639,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	778,460,670.29	1,574,639,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	778,460,670.29	1,574,639,600.00
1330	Төсвийн захирагчдаас	90,277,020.00	-
133003	Хөрөнгийн	90,277,020.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>868,012,690.29</u>	<u>1,573,305,800.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	868,012,690.29	1,573,305,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,412,690.29	967,877,684.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,411,519.68	726,207,637.85
210101	Үндсэн цалин	335,695,291.83	414,508,997.84
210102	Нэмэгдэл	86,598,064.19	126,486,163.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64,947,256.24	121,489,534.29
210104	Урамшуулал	62,170,907.42	63,722,942.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,053,219.77	95,464,678.01
210201	Тэтгэврийн даатгал	51,103,464.06	46,806,178.01
210202	Тэтгэмжийн даатгал	6,012,172.17	12,164,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,413,737.82	9,731,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,047,622.36	2,432,900.00

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

210205	Эрүүл мэндийн даатгал	10,476,223.36	24,329,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,208,000.00	45,472,000.00
210304	Байрны түрээс	68,208,000.00	45,472,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,744,512.84	30,284,199.09
210401	Бичиг хэрэг	3,864,900.00	6,851,530.00
210402	Тээвэр, шатахуун	6,876,800.00	15,629,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,801,962.84	4,578,009.09
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	264,000.00	1,050,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,936,850.00	2,174,700.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,340,500.00	2,571,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	581,000.00
210604	Урсгал засвар	1,340,500.00	1,990,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	152,174,938.00	59,388,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142,863,020.00	49,300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,125,900.00
210807	Газрын төлбөр	8,959,758.00	8,464,570.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	352,160.00	497,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	480,000.00	8,489,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,349,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	480,000.00	1,140,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,600,000.00	605,428,115.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,600,000.00	7,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,600,000.00	7,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	598,028,115.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	598,028,115.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	725,000.00	1,509,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	725,000.00	1,509,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	725,000.00	1,509,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	725,000.00	1,509,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	725,000.00	1,509,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(725,000.00)	(1,509,800.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,169,845,440.00	00.00	10,898,979,519.78	13,068,824,959.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,169,845,440.00	00.00	10,898,979,519.78	13,068,824,959.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(409,787,648.72)	(409,787,648.72)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,169,845,440.00	00.00	10,489,191,871.06	12,659,037,311.06
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,169,845,440.00	00.00	10,489,191,871.06	12,659,037,311.06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,169,845,440.00	00.00	10,489,191,871.06	12,659,037,311.06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	190,962,630.49	190,962,630.49
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,169,845,440.00	00.00	10,680,154,501.55	12,849,999,941.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,574,639,600.00	976,787,484.95	597,852,115.05	62.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,574,639,600.00	976,787,484.95	597,852,115.05	62.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,574,639,600.00	969,387,484.95	605,252,115.05	61.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,216,462,500.00	726,207,637.85	490,254,862.15	59.7
210101	Үндсэн цалин	661,762,400.00	414,508,997.84	247,253,402.16	62.6
210102	Нэмэгдэл	240,008,900.00	126,486,163.72	113,522,736.28	52.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	220,110,000.00	121,489,534.29	98,620,465.71	55.2
210104	Урамшуулал	94,581,200.00	63,722,942.00	30,858,258.00	67.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,057,900.00	95,464,678.01	56,593,221.99	62.8
210201	Тэтгэврийн даатгал	103,399,400.00	46,806,178.01	56,593,221.99	45.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,208,000.00	45,472,000.00	22,736,000.00	66.7
210304	Байрны түрээс	68,208,000.00	45,472,000.00	22,736,000.00	66.7
2104	Хангамж, бараа материалын зардал	34,164,300.00	30,284,199.09	3,880,100.91	88.6
210401	Бичиг хэрэг	3,865,000.00	6,851,530.00	(2,986,530.00)	177.3
210402	Тээвэр, шатахуун	16,896,000.00	15,629,960.00	1,266,040.00	92.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,770,800.00	4,578,009.09	5,192,790.91	46.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,260,000.00	1,050,000.00	210,000.00	83.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,372,500.00	2,174,700.00	197,800.00	91.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,081,000.00	4,081,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	581,000.00	581,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,500,000.00	3,500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,615,900.00	59,388,070.00	24,227,830.00	71.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,800,000.00	49,300,000.00	4,500,000.00	91.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,275,000.00	1,125,900.00	149,100.00	88.3
210807	Газрын төлбөр	27,715,900.00	8,464,570.00	19,251,330.00	30.5
210809	Улсын мэдээллийн	825,000.00	497,600.00	327,400.00	60.3

**НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

	маягт хэвлэх, бэлтгэх				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,550,000.00	8,489,900.00	60,100.00	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,410,000.00	7,349,900.00	60,100.00	99.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,140,000.00	1,140,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,500,000.00	7,400,000.00	100,000.00	98.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,500,000.00	7,400,000.00	100,000.00	98.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,500,000.00	7,400,000.00	100,000.00	98.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,574,639,600.00	976,787,484.95	597,852,115.05	62.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,574,639,600.00	976,787,484.95	597,852,115.05	62.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,574,639,600.00	976,611,484.95	598,028,115.05	62.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	176,000.00	(176,000.00)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	43.00	21.00	22.00	48.8
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	14.00	22.00	38.9
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	43.00	21.00	22.00	48.8
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	37.00	15.00	22.00	40.5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын үйл ажиллагааны чиг үүргийг “Нийслэлийн гэр хороолол, хот суурин газрыг дахин төлөвлөн барилгажуулж, нийгмийн болон инженерийн дэд бүтцээр хангагдсан орон сууцны хорооллыг барьж байгуулах, инженерийн дэд бүтэц, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, түрээсийн олон төрөлт болон иргэдийн орлогод нийцсэн, байгаль орчинд ээлтэй, сэргээгдэх эрчим хүчний шинэлэг технологи бүхий орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийг орон сууцны нэгдсэн бодлоготой уялдуулан зохион байгуулах, хяналт тавих” гэж тодорхойлсон.

Нийслэлийн Нийслэлийн Орон сууцны бодлогын газар нь тайлант жилийн үйл ажиллагааны зорилгоо “Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төвлөрлийг сааруулах зорилгоор хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дэд төвийн байршилд гэр хорооллыг орон сууцжуулах” гэж тодорхойлон дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих;
- Гэр хорооллыг нийгмийн болон инженерийн дэд бүтцээр хангагдсан орон сууцны хороолол болгон хөгжүүлэх;
- Иргэдийн амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын багц хууль шинээр батлагдсан;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай”;
- ЗГ-ын 2024 оны 82 дугаар тогтоол “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай журам”;
- ЗГ-ын 2024 оны 2 дугаар тогтоол “Худалдан авах ажиллагаанд төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай”;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт хүчингүй болсон.

Тус байгууллагад дотоод аудитын алба байхгүй бөгөөд тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны санхүүгийн чиг үүргийг удирдах шатны ажилтнууд хэрэгжүүлдэг байна. .

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Орон сууцны бодлогын газар нь даргын тушаалаар 2017 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 190,962.6 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	20,100.0	20,100.0	-
Бараа материал	56,918.7	33,730.8	(23,187.9)
Үндсэн хөрөнгө	4,699,974.5	4,914,125.0	214,150.5
Нийт хөрөнгө	12,659,037.3	12,849,999.9	190,962.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	12,659,037.3	12,849,999.9	190,962.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	12,659,037.3	12,849,999.9	190,962.6

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 20,100.0 мянган төгрөг нь өмнөх онуудаас үүссэн авлага бөгөөд орон сууцны дахин төлөвлөлттэй холбоотой нэг хуулийн этгээдээс ИХАШШ-ийн “Гэрээний үүрэг хангуулах, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай” 2022 оны шийдвэр, 2023 оны тус шүүхийн гүйцэтгэх хуудас, шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгүүлэх тухай захирамжаар төлүүлэхээр шийдвэрлэсэн авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 33,730.8 мянган төгрөг болж 23,187.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 33,607.6 мянган төгрөгийн материалын өсөлт болон 29,857.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 26,938.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна. Бараа материалын нийт үлдэгдэл нөөцийн 33.6 хувийг тусгай

зориулалтын материал (*Сэргээгдэх эрчим хүчний ТЭЗҮ-12,000.0 мянган төгрөг*), 51.1 хувийг бусад хангамжийн материал (*утасны аппарат, уртасгагч, макет, стэнд....*) эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,914,125.0 мянган төгрөг болж 214,150.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,509.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж" төслийн хүрээнд үнэ төлбөргүй ирсэн 222,625.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Хот байгуулалт, Хотын стандартын газраас 1,491,903.5 мянган төгрөгийн "Барилгажилтын зураг төсөв"-ийг балансаас балансад шилжүүлэн авч "бусад биет бус хөрөнгө" дансанд бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,849,999.9 мянган төгрөг болж, 190,962.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,252.958.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 321,680.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,574,639.6 мянган төгрөгөөр баталжээ. Үүнд: Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 341,575.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 42,697.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж, бараа материалын зардлыг 9,746.6 мянган төгрөг, нормативт зардлыг 3,325.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 3,405.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 12,900.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 33,308.8 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь тайлан онд тус газарт шинээр ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган шинээр барих үйл ажиллагааны хүрээнд 10 орон тоотой "Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтэс" шинээр нэмэгдэж бүтцийн өөрчлөлт хийгдсэнтэй холбоотой цалингийн зардлыг нэмэгдүүлэн төсвийг тодотгон баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт" 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 1,197,224.6 мянган төгрөгийг баталсан ба Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/443 дугаар захирамжаар тус газарт Хот байгуулалт, хотын стандартын газраас 10 хүний орон тоотой "Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтэс" шилжиж ирж байгаатай холбоотой төсвийн тодотгол хийж, 1,574,639.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,574,639.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны зардалд 976,787.5 мянган төгрөгийг зарцуулан, зарцуулагдаагүй үлдэгдэл 597,852.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 176.0 мянган төгрөг, нийт 598,028.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 976,787.5 мянган төгрөг буюу 62.0 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 490,254.9 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 56,593.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22,736.0 мянган төгрөг, бусад зардлыг 28,268.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт %
1	71407-Агаарын бохирдлыг бууруулах	1,574,639.6	976,787.5	597,852.1	62.0
1-1	80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал	1,513,339.6	920,087.5	593,252.1	60.8
1-2	80205 - Мэдээлэл, сурталчилгааны зардал	25,000.0	22,900.0	2,100.0	91.6
1-3	80219 – Харуул хамгаалалтын зардал	28,800.0	26,400.0	2,400.0	91.7
1-4	80802 - Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	7,500.0	7,400.0	100.0	98.6
	ДҮН	1,574,639.6	976,787.5	597,852.1	62.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн Орон сууцны бодлогын газар тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийслэлийн Орон сууцны бодлогын газар нь тайлант онд урсгал үйл ажиллагааны төсвөөс 45 аж ахуйн нэгжээс 133,656.5 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнээс: бичиг хэрэг, шатахуун, бусад хангамжийн материалын худалдан авалтыг 21 аж ахуйн нэгжтэй 24,523.7 мянган төгрөг, харуул хамгаалалт болон түрээсийн үйлчилгээнд 2 аж ахуйн нэгжтэй 66,188.0 мянган төгрөг, интернэт, шуудан холбоо, мэдээлэл технологийн зардлыг 10 аж ахуйн нэгжтэй 19,614.2 мянган төгрөг, сургалт зохион байгуулахаар 2 иргэнтэй 550.0 мянган төгрөгийн гэрээ тус тус хийж гүйцэтгүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын батлагдсан орон тоог бүрэн ажиллуулж хүний нөөцийг хангах, ажил хавсран гүйцэтгэж байгаа албан хаагчийн ажлын ачаалал, амралтыг зохицуулах, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тухай бүр бүрэн байршуулах, батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөн батлах, дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээх, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг цахим системд мэдээлж байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн ахлах аудитор Н.Баттогоо, аудитор Р.Баярмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/96 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг, суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 887,670.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,315.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэж батлагдсан орон тоог хэвээр хадгалж, цалин хөлсийг ажлын гүйцэтгэлээр олгож ажилласан байна.

Төсвийн шууд захирагч нь цахим дэлгүүрт бүртгэлгүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт хүргүүлээгүй, албан хэрэгцээнд 21,055.3 мянган төгрөгийн бараа материалыг цахим дэлгүүрээс аваагүй, нэр бүхий 8 аж ахуйн нэгжээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиалгын хүсэлтийг илгээж, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж өгөв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 102,079.4 мянган зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус газар нь шилэн дансны цахим хуудсанд 1,612,417.0 мянган төгрөгийн 26 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1.ТБОНӨХБАҮХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn сайтад ил тодоор байршуулаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.3-д "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөн батлах, дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээх, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг цахим системд мэдээлж байх зөвлөмж өгөв.

2.Тайлант онд 26 албан хаагчид 1556 цагийн 33,305.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл, 10 албан хаагчид 47,718.5 мянган төгрөгийн ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин олгосон байна. Төсвийн шууд захирагч нь батлагдсан орон тоог бүрэн

ажиллуулж хүний нөөцийг хангах, ажил хавсран гүйцэтгэж байгаа хүний ажлын ачаалал, амралтыг зохицуулж, зохион байгуулалт хийгээгүй байна.

Энэ нь УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4-д Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-д "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тоог бүрэн ажиллуулж хүний нөөцийг хангах, ажил хавсран гүйцэтгэж байгаа хүний ажлын ачаалал, амралтыг зохицуулж, зохион байгуулалт хийх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдын хувьд горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, нийт 63,233.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 3 зөвлөмжийг хүргүүлсний хэрэгжилтийг шалгахад бүрэн хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 91,097.3 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	91,097.3	2	91,097.3	100.0
Нийт дүн	2	91,097.3	2	91,097.3	100.0

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлагын дансны үлдэгдэлтэй холбоотой шүүгчийн захирамжийн хэрэгжилт, ажиллагаа явуулах гэрээ, ажиллагааны явцыг нарийвчлан үзэх шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 474,515.9 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны хуримтлагдсан үр дүнг 474,515.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Аудитаар 1 зөрчил² илэрч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13,315.1 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн нөөцийн бараа дансанд бүртгэлтэй байгаа 56,747.8 м.кв газрын эзэмших эрхийн гэрчилгээ, холбогдох анхан шатны баримтууд байхгүй байна.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-д “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн нөөцийн бараа дансанд бүртгэлтэй газрын анхан шатны баримтыг бүрдүүлэн баталгаажуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг өөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, мэдэглээгүй орхисон/,
² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны хуримтлагдсан үр дүнг 474,515.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	474,515.9			1	474,515.9	1	474,515.9				
Дүн	1	474,515.9			1	474,515.9	1	474,515.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Санхүүгийн тайлангийн нөөцийн бараа дансанд бүртгэлтэй байгаа 56,747.8 м.кв газрын эзэмших эрхийн гэрчилгээ, холбогдох анхан шатны баримтууд байхгүй байна.	1	-					1	-				
Дүн	1	-					1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Тайлант онд 36 албан хаагчид нийт илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин олгосон. Батлагдсан орон тоог бүрэн ажиллуулж хүний нөөцийг хангах, ажил хавсран гүйцэтгэж байгаа хүний ажлын ачаалал, амралтыг зохицуулж, зохион байгуулалт хийгээгүй байна.	1	81,024.1			1	81,024.1
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлээгүй.	1	-			1	-
Цахим дэлгүүрээс бараа материалын худалдан авалт хийгээгүй байна.	1	21,055.3			1	21,055.3
Дүн	3	102,079.4			3	102,079.4
Нийт дүн	3	102,079.4			3	102,079.4

Утас: +976 70007734
Факс: +976 70007734

Цахим шуудан: ub@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Нийслэлийн өмчийн нэгдүгээр байр,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар
дүүрэг Улаанбаатар-15160, Монгол Улс